



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар A/198

Мандалговь

Г Зардал гаргах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.16, 60.1.21, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 58 дугаар зүйлийн 58.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтын 2.3, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.8, 5.1.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, газрын доройтол, цөлжилтийг сааруулах, экологийн тэнцвэрт байдлыг хангах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа олон талт ажлуудыг эрчимжүүлэх үүднээс “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэн иргэдэд мод тарих, услах, арчлан ургуулах мэдлэг дадлагыг олгох зорилгоор аймгийн “Ногоон хөгжлийн зөвлөгөөн”, “Дундговио ногооруулъя” сургалтыг зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Зардалд шаардагдах 5,935,100 (таван сая есөн зуун гучин таван мянга нэг зуу) төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн “Дундговио ногооруулъя” төсөл арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхтайван) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ



4822100366